



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020.07.28 № 241

танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМ-д

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Иргэний хөдөлгөөний намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох Иргэний хөдөлгөөний нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгуулагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Иргэний хөдөлгөөний намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020”, Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

015030439

Дүгнэлт

Иргэний хөдөлгөөний намын Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэний хөдөлгөөний намын мөрийн хөтөлбөр / ... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Аймгийн сонгуулийн хороонд

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН

015030440

ИХ намын Улс төрийн зөвлөлийн
2020 оны 06-р сарын 22-ны өдрийн
хурлаар батлав.

**ИХ НАМЫН АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**“БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ 2030”
ЭРХЭМ ЗОРИЛГО**

1. Орон нутгийн бүтээн байгуулалтыг иргэдийн оролцоотойгоор өрнүүлж 2030 онд бүс нутагтаа тэргүүлэгч, 2044 онд эх дэлхийдээ тэргүүлэгч улс үндэстэн болох.
2. Монгол Улсын иргэнд тулгамдсан асуудал бол аймаг, нийслэл, сум, дүүргийн тулгамдсан асуудал гэсэн гол зарчмыг мөрдлөг болгож, оновчтой хөрөнгө оруулалтын бодлого хэрэгжүүлэх замаар, үргүй зардлыг бууруулна.
3. Шударга, хөгжингүй улс болгох гол хүч болсон Монгол хүнийг үндэсний үнэт зүйлтэй, эв нэгдэлтэй, бие биенээ харилцан дэмжин хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн иргэнд суурилсан эрүүл тогтолцоог бий болгоно.
4. Ил тод, нээлттэй, эрх чөлөөтэй, ардчилсан, хариуцлагатай, иргэддээ бүрэн эрхийн бололцоог олгосон, бүх шатанд ил тод нээлттэй тогтолцоог бий болгоно.
5. Орон нутгийн хөгжилд Хөдөө аж ахуй, Аялал жуулчлалын салбарыг чухалчлан авч үзэж суурь эдийн засгийн салбар болгон хөгжүүлнэ.
6. Орон нутгийн нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд нөлөөлөх, оролцох иргэдийн идэвхтэй, эерэг хандлагатай оролцоог нэмэгдүүлнэ.
7. Үндэсний өнгө төрхтэй иргэндээ ээлтэй, аюулгүй сууринг иргэдийн дэмжлэгтэй байгуулна.

**“БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ 2030”
БАРИМТЛАХ ЗАРЧИМ**

Энэхүү мөрийг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах суурь зарчмыг баримтална.

- Аливаа залгамж халаатай, үүслийг үргэлжлүүлэх бүтээлч санаачилга бол хөгжлийн үндэс гэж үзнэ.
- Нэг иргэн нэг амьдрал гэсэн суурь зарчмыг мөрдлөг болгож, хүн бүрийг гэр бүл, хамт олонд нь хариуцуулж, “Бусдын алдаа надаас болдог, хохирол нь намайг хорлодог” зарчмыг дээдэлнэ.
- Өвөг дээдсийн өвлүүлсэн зан заншил, ёс суртахууны амин мөн чанарыг нандигнан хадгалж, төр ёсны зарчмыг түгээн дэлгэрүүлнэ.
- Салбарын суурь шинжтэй өөрчлөлтийг мэргэжлийн, салбарынхны үзэл бодолд суурилж хэрэгжүүлнэ.
- “Мууг устгахаас дутууг нь нөхсөн нь дээр. Аливаа юм муудсан шалтгаан нь дутагдсанд юм уу илүүдсэнд оршино. Дутагдсаныг нь нөхөөд илүүдсэнийг тэгшилбэл тэр юм угтаа сайн зүйл болдог” зарчмыг мөрдөж харилцааны хурдыг бий болгоно.



Handwritten signature

**“БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ 2030”
ТЭРГҮҮЛЭХ 13 ЗОРИЛТ**

1. Улс төрийн намын гишүүнчлэлээс болж, ард иргэд талцан хуваагдаж иргэдийн нийтлэг эрх ашиг хохирдог явдлыг үндэсний үнэт зүйл дээр тулгуурласан улс төрийн харилцаанд шилжүүлж арилгана.
2. Орон нутагт тулгамдсан асуудлыг үндэсний хэмжээний цогц, оновчтой хөрөнгө оруулалтын бодлого хэрэгжүүлэх замаар бууруулна.
3. Төрийн бус байгууллагуудыг сонгодог иргэний нийгмийн байгууллагын зарчмаар ажиллах бие даасан тогтолцоог бий болгоно.
4. Хүүхэд, залуучууд, ахмадуудыг нийгэм, байгаль зүйн шаардлага онцлогт нийцсэн бодлогоор хөгжүүлж, бүтээн байгуулалтад оролцуулна.
5. НҮБ-н Тогтвортой хөгжлийн зорилт, түүнд нийцүүлэн гаргасан Монгол Улсын холбогдох хууль, бодлого, зорилтын хүрээнд байгаль орчинд ээлтэй эрүүл орчныг орон нутагт бүтээн байгуулна.
6. Нийгэм, Дэд бүтэц, Хөдөө аж ахуй, Аялал жуулчлалын салбарт их бүтээн байгуулалтыг өрнүүлж, Монгол ажиллах хүчнийг сургах, дадлагажуулах системийг бий болгоно.
7. Хот суурингийн хөгжлийн бодлогыг иргэдийн хурлын танхимаар хязгаарладаг явдлыг эцэс болгож, иргэдээр хэлэлцүүлж хэрэгжүүлдэг болно.
8. Үндэсний үйлдвэрлэлийг гадаадын зах зээлд гаргах төрийн болон үндэсний маркетингийн цогц бодлогыг иргэд аж ахуйн нэгжийн хүчээр хэрэгжүүлнэ.
9. Тэргүүлэх салбаруудад бүтээлч, инновацид суурилсан санал санаачилгыг нэвтрүүлэхэд учрах хүнд суртлыг хална. Хот, суурингийн хөгжилд иргэдийн санаачлага нэвтрүүлэх, иргэдийн хүчээр хотын соёлыг дээшлүүлнэ.
10. Төрөөс олгох тусгай зөвшөөрлийг туршлагад суурилсан давуу байдлаас шинэ санаачилга, шинэ технологийг нэвтрүүлэхэд суурилсан өрсөлдөөнт тогтолцоонд шилжүүлнэ.
11. Иргэнд тулгарч буй бэрхшээлийг дан ганц төрийн байгууллагаар шийдүүлэх тогтолцоог халж, нийгмийн хариуцлагын шинэ хандлага, тогтолцоог хөгжүүлнэ.
12. Төрийн үйлчилгээг шинэ арга барилд шилжүүлнэ. Төрийн өндөр алба тушаалтнуудыг хөрөнгө орлогын мэдүүлгийг бүх иргэдэд хянуулах тогтолцоог бий болгоно.
13. Хөдөө аж ахуй, Аялал жуулчлалын салбарыг орон нутгийн ард иргэдийн оролцоотойгоор аж ахуй, бараа түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн түвшинд олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх суурь бүтцийг бүтээн байгуулна.



Handwritten signature

